



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 03-ны өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

**Эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааны
бодлого батлах тухай**

Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг хангах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах, засаглалын тогтолцоог бэхжүүлэх, үйл ажиллагааны тасралтгүй бөгөөд тогтвортой байдлыг хангах зорилгын хүрээнд Эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааны бодлогыг тодорхойлон батлах тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалтыг үндэслэн Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**



Нэг. Говь ХК-ийн “Эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааны бодлого”-ыг Хавсралт-1 ёсоор баталсугай.

Хоёр. Энэхүү бодлогын хэрэгжилтийг ханган, дотоод дүрэм журмыг боловсруулан баталж, холбогдох хөтөлбөрийг шат дараатай хэрэгжүүлэн, тасралтгүй сайжруулалтыг хийн ажиллахыг ТУЗ-ийн нийт гишүүд, Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/, Хүний нөөц хариуцсан захирал /Д.Соёлмаа/, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга /М.Сэлэнгэ/ нарт үүрэг болгосугай.

ТУЗ-ийн ДАРГА 










Д.ГЭРЭЛМАА


	ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО	
---	--	--




БАРИМТ БИЧГИЙН НЭР:

ГОВЬ ХК-ИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ЗАЛГАМЖ
ХАЛААНЫ БОДЛОГО


БАРИМТ БИЧГИЙН ХАРИУЦАГЧ	ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА		
БАРИМТ БИЧГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ	ГОВЬ ХК-ИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУД		
БАТЛАГДСАН ОГНОО	2023.02.03		
БАРИМТ БИЧГИЙН НУУЦЛАЛЫН ЗЭРЭГЛЭЛ	НЭЭЛТТЭЙ	БАРИМТ БИЧГИЙН ТҮВШИН	T1

	АЛБАН ТУШААЛ	НЭР	ГАРЫН ҮСЭГ
БАТАЛСАН:	ТУЗ-ИЙН ДАРГА	Д.ГЭРЭЛМАА	
ХЯНАСАН:	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Ц.БААТАРСАЙХАН	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	М.БАЯР	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Ж.ОЮУНЧИМЭГ	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	А.ЖАРГАЛМАА	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Д.ХУЛАН	
	ТУЗ-ИЙН ГИШҮҮН	Д.ХҮРЭЛБААТАР	

	<p>ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО</p>	<p>Дугаар: Б-ТУЗ-05-02</p>
---	--	--------------------------------

	ТХХ-ИЙН ДАРГА	Э.ИВГЭЭЛ	
БОЛОВСРУУЛСАН:	ХҮНИЙ НӨӨЦ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ	Д.СОЁЛМАА	
	ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	М.СЭЛЭНГЭ	

Улаанбаатар хот
2023 он

	<p style="text-align: center;">ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО</p>	<p style="text-align: center;">Дугаар: Б-ТУЗ-05-02</p>
---	--	--


Баримт бичгийн өөрчлөлтийн бүртгэл			
Хувилбарын дугаар	Хүчин төгөлдөр болсон огноо	Өөрчлөлт оруулж, боловсруулсан албан тушаалтан	Өөрчлөлтийн утга (баримт бичигт ямар өөрчлөлт орсныг товч тайлбарлана)
01	2023.02.03	Хүний нөөц хариуцсан захирал Д.Соёлмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ	Баримт бичгийн анхны хувилбар

Баримт бичгийн төлөв		
Эх хувь	Албан хэрэгцээний хувь	Хүчингүй хувь
<div style="border: 1px solid red; padding: 5px; width: fit-content;"> <p style="text-align: center; color: red;">ГОВЬ ХК ЭХ ХУВЬ</p> <p>Гарын үсэг: <i>Ариунзала</i> 2023 он 02 сар 06 өдөр</p> </div>		

ИШ ТАТСАН БАРИМТ БИЧГҮҮД		
№	Баримт бичгийн нэр	Бүртгэлийн дугаар
1	"Компанийн засаглалын кодекс"	Санхүүгийн зохицуулах хорооны 2022.03.23-ны №145 тогтоол
2	"Компанийн тухай хууль"	УИХ-ын 2011.10.06-ны хурлаар батлагдсан, сүүлд 2022.06.17-нд нэмэлт өөрчлөлт орсон
3	"Говь ХК-ийн дүрэм"	Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020.04.24-ний №02 тогтоол
4	Говь ХК-ийн "Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны бодлого"	Б-ТХХ-08-01

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	5
1.1 Зорилго	5
1.2 Хамрах хүрээ	5
1.3 Нэр томъёоны тайлбар	5
2. БОДЛОГО	6
2.1 Залгамж халааны бодлого	6
2.2 Залгамж халааны зорилт	7
2.3 Залгамж халааны зарчим	9
2.4 Гэнэтийн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ	9
3. МАНЛАЙЛАЛ БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА.....	10
3.1 Залгамж халааны бодлогын үүрэг, хариуцлага	10
3.2 Хяналт ба үнэлгээ	11

	<p>ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО</p>	<p>Дугаар: Б-ТУЗ-05-02</p>
---	--	--------------------------------

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

1.1.1 Энэхүү бодлогын зорилго нь Говь ХК (цаашид “Компани” гэх)--ийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах томоохон хүчин зүйл болсон Эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааны тогтвортой байдлыг хадгалахад баримтлах бодлогыг тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх арга зам болсон зорилтууд, баримтлах зарчим болон гэнэтийн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход оршино.

1.2 Хамрах хүрээ

1.2.1 Энэхүү бодлого нь олон нийтэд нээлттэй байх бөгөөд компанийн ЭБАТ-ууд буюу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Менежмент багийн удирдлагуудад хамаарна.

1.2.2 Энэхүү бодлогыг Монгол улсын Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон компанийн Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны бодлогын хүрээнд боловсруулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

1.3 Нэр томьёоны тайлбар

1.3.1 Уг бодлогын хүрээнд дараах нэр томьёог ашиглана.

1.3.1.1 **Эрх бүхий албан тушаалтан:** Компанийн ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, дэд захирлууд, газрын захирлууд, хуулийн зөвлөх, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог удирдах албан тушаалтнууд;

1.3.1.2 **Төлөөлөн удирдах зөвлөл:** Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага бөгөөд компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл бодлогыг тодорхойлж, санхүү, үйл ажиллагааны үр ашигтай байдал болон Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналтыг тавьж, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хангах, компанийн засаглалын хэрэгжилтийг хариуцах гол субъект бөгөөд компанийн

дүрмээр ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг 9 буюу түүнээс гишүүнтэй байхаар тогтоосон.

- 1.3.1.3 **Гүйцэтгэх захирал:** Хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн, компанийн ашигт ажиллагааны түвшинг өсгөх замаар хувьцаа эзэмшигчдийн хүртэх өгөөжийг нэмэгдүүлэх, компанийн алсын хараа, стратегийн зорилт, бизнес төлөвлөгөөний биелэлтийг хангахад чиглэн компанийн үйл ажиллагааг удирдлагаар хангах, шийдвэр гаргах эрх үүргийг хүлээсэн ТУЗ-ийн шийдвэрээр томилогдсон удирдагч;
- 1.3.1.4 **Менежмент баг:** Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, шийдвэр гаргах эрх үүргийг хүлээсэн Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогдсон удирдлагын баг буюу түүний бүрэлдэхүүн;
- 1.3.1.5 **Нэр дэвшүүлэх хороо:** ТУЗ-ийн дэргэдэх хороо бөгөөд компанийн ЭБАТ-ууд буюу ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, Менежмент багийн удирдлагуудын талаар баримтлах бодлогыг тодорхойлох, тэдгээрийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөн хяналт удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилго бүхий хороо;

1.3.2 Товчлол: Баримт бичигт дор дурдсан товчилсон үгийг ашиглаж болно.


Хүснэгт 1 Товчилсон үгийн тайлбар

№	Товчилсон үгийн тайлбар	Товчилсон үг
1	Эрх бүхий албан тушаалтан	ЭБАТ
2	Төлөөлөн удирдах зөвлөл	ТУЗ
3	Нэр дэвшүүлэх хороо	НДХ
4	Хүний нөөцийн газар	ХНГ

2. БОДЛОГО

2.1 Залгамж халааны бодлого

- 2.1.1 НДХ болон ХНГ нь компанийн дотоод болон гадаад зах зээлийн өөрчлөлт, бизнесийн урт хугацааны стратеги төлөвлөгөө, өсөлт хөгжилтэй уялдуулан ЭБАТ-уудад тавигдах шаардлага, мэдлэг мэргэжил, ур чадварын шалгуурыг оновчтой тодорхойлно.


	<p style="text-align: center;">ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО</p>	<p style="text-align: center;">Дугаар: Б-ТУЗ-05-02</p>
---	---	--

- 2.1.2 НДХ болон ХНГ нь ЭБАТ-уудыг сонгон шалгаруулахад баримтлах зарчим, шалгуур үзүүлэлт, залгамж халааг бэлтгэх төлөвлөгөө болон ур чадварыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулалт хийнэ.
- 2.1.3 Компанийн зүгээс ЭБАТ-уудыг тогтвор суурьшилтай сэтгэл ханамжтай ажиллах нөхцөл, ажлын байран дээр өсөж дэвших боломжоор хангана.
- 2.1.4 ТУЗ нь энэхүү бодлогын хэрэгжилтийг хангах замаар удирдах албан тушаалтны орон тоо гэнэт буюу төлөвлөгдөөгүй байдлаар өөрчлөгдсөнөөс үүдэн хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудын эрх ашиг хохирох эрсдэлтэй нөхцөл үүсгэхгүйн тулд ЭБАТ-уудын залгамжлагч хүний нөөцийн бэлэн байдлыг тогтмол бүрдүүлж, компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хадгалах зохистой тогтолцоог бүрдүүлнэ.

2.2 Залгамж халааны зорилт

2.2.1 ТУЗ-ийн гишүүдийн залгамж халаа

- 2.2.1.1 НДХ нь ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдэд тавигдах ур чадвар, мэргэжил боловсрол, ажлын туршлага, хувь хүний зан чанар зэргийг багтаасан шалгуур үзүүлэлт, ТУЗ-ийн гишүүдийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журмыг боловсруулан ТУЗ-ийн хурлаар батлуулна.
- 2.2.1.2 ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, шинээр болон улираан нэр дэвшүүлэх нөхцөл байдал үүсэх үед НДХ нь дотоод болон гадаад эх үүсвэрээс сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй байдлаар зарлан явуулж, нэр дэвшигчдийг үнэлэн тодорхойлж нэр дэвшүүлэх саналыг гаргах бөгөөд Хувьцаа эзэмшигчдийн хурлаар томилно.
- 2.2.1.3 ТУЗ-ийн зүгээс ТУЗ-ийн гишүүдийн эрх үүргийг тодорхойлсон үйл ажиллагааны журмыг батлах бөгөөд ТУЗ-ийн ажлын алба нь шинээр томилогдсон ТУЗ-ийн гишүүддээ компанийн болон ТУЗ-ийн үйл ажиллагааны талаар цэгцтэй нэгдсэн ойлголтыг өгөх зорилгоор гарын авлагыг боловсруулан ТУЗ-ийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангана.
- 2.2.1.4 ТУЗ-ийн ажлын алба нь ТУЗ-ийн гишүүдийн залгамж халааны тасралтгүй байдлыг хадгалах зорилгоор нэр дэвшигчдээс ирүүлсэн

	<p style="text-align: center;">ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО</p>	<p style="text-align: center;">Дугаар: Б-ТУЗ-05-02</p>
---	---	--

материалыг хадгалж, гэнэтийн тохиолдолд шууд нэр дэвшүүлэх боломжтой хүмүүсийн жагсаалтыг гарган, тогтмол шинэчилнэ.

2.2.2 Гүйцэтгэх захирлын залгамж халаа

2.2.2.1 НДХ нь Гүйцэтгэх захиралд нэр дэвшигчид тавигдах ур чадвар, мэргэжил боловсрол, ажлын туршлага, хувь хүний зан чанар зэргийг багтаасан шалгуур үзүүлэлтийг тодорхойлон баталж, тасралтгүй сайжруулна.

2.2.2.2 Гүйцэтгэх захирлын албан тушаалд шинээр болон улираан нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх нөхцөл байдал үүссэн тохиолдолд ТУЗ нь дотоод болон гадаад эх үүсвэрээс тохирох хүнийг сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэх санал гаргах бөгөөд ТУЗ-ийн хурлаар томилно.

2.2.2.3 НДХ нь Гүйцэтгэх захирлын эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлсон Менежментийн гэрээний нөхцөлийг боловсруулах бөгөөд гэрээний агуулгыг ТУЗ-ийн хурлаар батлан, ТУЗ-ийн дарга Гүйцэтгэх захиралтай Менежментийн гэрээг байгуулна.

2.2.2.4 ТУЗ-ийн зүгээс Гүйцэтгэх захирлын залгамж халааны бодлогын хэрэгжилтийг хангах журмыг тодорхойлон батална.

2.2.3 Менежмент багийн удирдлагуудын залгамж халаа

2.2.3.1 ХНГ нь Гүйцэтгэх захирлын хамтаар Менежмент багийн удирдах албан тушаалд нэр дэвшигчид тавигдах ур чадвар, мэргэжил боловсрол, ажлын туршлага, хувь хүний зан чанар зэргийг багтаасан шалгуур үзүүлэлтийг тодорхойлон Гүйцэтгэх захирлаар батлуулж, тасралтгүй сайжруулна.

2.2.3.2 Менежмент багийн удирдлагуудын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, шинээр томилох, чөлөөлөх нөхцөл байдал үүсэх үед ХНГ-аас дотоод болон гадаад эх үүсвэрээс тохирох нэр дэвшигчийг тодорхойлж, санал болгох бөгөөд Гүйцэтгэх захирлын шийдвэрээр томилно.

2.2.3.3 ХНГ нь Гүйцэтгэх захирлын хамтаар Менежмент багийн удирдлагуудын шалгуур үзүүлэлтэд нийцэх залгамжлагчийг хөгжүүлэх төлөвлөгөө (хувь хүний хөгжлийн төлөвлөгөө) болон тогтоон барих хөтөлбөрийг

боловсруулах ба хэрэгжүүлэх, үнэлж дүгнэх замаар залгамж халааны бодлогыг хэрэгжүүлэх бөгөөд тасралтгүй сайжруулалтыг хийнэ.

2.2.3.4 Өндөр насны тэтгэвэрт гарах болон таамаглаж болохуйц сул орон тоонд шаардлага хангасан нэр дэвшигчийг урьдчилан тодорхойлохын тулд ХНГ нь жил бүрийн давтамжтайгаар судалгаа хийнэ.

2.3 Залгамж халааны зарчим

- 2.3.1 **Ил тод байдлыг хангах:** ЭБАТ-уудыг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, томилох, залгамж халааг төлөвлөх бүхий л үйл ажиллагаанд мэдээллийн ил тод байдлыг эрхэмлэн, оролцогч талуудыг үнэн зөв мэдээллээр цаг хугацаанд нь ханган ажиллана.
- 2.3.2 **Хүн бүрт ижил тэгш боломжийг олгох:** ЭБАТ-уудын залгамж халааг бэлтгэх, томилохдоо хүн бүрт ижил боломжийг олгон, эрх тэгш хандана.
- 2.3.3 **Шударга, ёс зүйтэй байх:** Компанийн эрх ашгийг хувийн эрх ашгаас ямагт дээгүүр тавьж, ёс зүйн зарчмыг баримтлан шударга шийдвэрийг гарган ажиллана.
- 2.3.4 **Дотоод эх үүсвэрээс залгамж халааг бүрдүүлэхийг зорих:** Залгамж халааны тасралтгүй бөгөөд тогтвортой байдлыг хангахдаа залгамжлагчийг дотоод эх үүсвэрээс бүрдүүлэхийг зорино.
- 2.3.5 **Хувь хүний хөгжил, сурч хөгжих боломжийг дэмжих:** Компанийн хэмжээнд хүний нөөцийн оновчтой бодлогоор дамжуулан нийт ажилтнуудын хувь хүний хөгжил болон сурч хөгжих боломжийг дэмжих арга хэмжээг авч ажиллана.
- 2.3.6 **Мэргэшсэн, тогтвортой багийг бүрдүүлэх:** ЭБАТ-уудын бүрэлдэхүүнийг олон улсын хэмжээнд өрсөлдөхүйц ур чадвартай, мэргэшсэн бөгөөд тогтвортой хүний нөөцөөр бүрдүүлэхийг зорино.
- 2.3.7 **Шинийг эрэлхийлэн, тасралтгүй сайжруулах:** Залгамж халааны хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулахдаа үргэлж шинийг эрэлхийлэх бөгөөд бодлогын баримт бичиг болон зарчмуудаа компанийн үйл ажиллагааны онцлог, стратеги зорилтод нийцүүлэн тасралтгүй сайжруулан ажиллана.

2.4 Гэнэтийн тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

- 2.4.1 Компанийн ЭБАТ нас барсан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан болон бусад урьдчилан тооцоолох боломжгүй, гэнэтийн шалтгааны улмаас албан тушаалаа

гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд ТУЗ, НДХ, Гүйцэтгэх захирал болон Хүний нөөц хариуцсан захирал нар яаралтай хуралдаж, тухайн ЭБАТ-ыг түр орлох этгээдийг сонгож томилно.


- 2.4.2 ТУЗ-ийн гишүүн урт хугацаанд чөлөө авах, өвчтэй байх болон бусад шалтгаанаар ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд түүнийг орлох этгээдийг ХЭХ-аар сонгох хүртэл НДХ-ны санал болгосноор ТУЗ түр томилж болно. Ингэхдээ компанийн “ТУЗ-ийн гишүүн сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх журам”-ыг баримтална.
- 2.4.3 Гүйцэтгэх захирал урт хугацаанд чөлөө авах, өвчтэй байх болон бусад шалтгаанаар ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд түүнийг орлох этгээдийг ТУЗ томилно.
- 2.4.4 Менежмент багийн удирдлагууд урт хугацаанд чөлөө авах, өвчтэй байх болон бусад шалтгаанаар ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд түүнийг орлох этгээдийг Гүйцэтгэх захирал томилно.

3. МАНЛАЙЛАЛ БА ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

3.1 Залгамж халааны бодлогын үүрэг, хариуцлага

Хүснэгт 2 Залгамж халааны бодлогын үүрэг, хариуцлагын матриц

Процесс	ТУЗ	НДХ	Гүйцэтгэх захирал	ХНГ	Менежмент багийн удирдлагууд	ТУЗ-ийн ажлын алба
<i>/Г-гүйцэтгэх, Х-хариуцах, З-зөвлөлдөн хамтран ажиллах, М-мэдээлэл авах/</i>						
Залгамж халааны бодлогыг боловсруулах, батлах	Х	Г	З, М	Г	З, М	Г
Залгамж халааны бодлогыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх	Г	Х, Г	Г	Г	Г	Г
Залгамж халааны бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, сайжруулах	З, М	Х, Г	Г	Г	З, М	Г
Шаардлагатай тохиолдолд шинэчлэх	Х	Г	З, М	Г	З, М	Г

	<p style="text-align: center;">ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ЗАЛГАМЖ ХАЛААНЫ БОДЛОГО</p>	<p style="text-align: center;">Дугаар: Б-ТУЗ-05-02</p>
---	--	--

- 3.1.1 ТУЗ нь ЭБАТ-уудын залгамж халааны бодлогыг хянан баталж, шаардлагатай тохиолдолд сайжруулалт хийн шинэчилнэ.
- 3.1.2 НДХ нь бодлогыг тодорхойлон боловсруулж, ТУЗ-ийн хурлаар батлуулах бөгөөд тус бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, залгамж халааны зорилтуудын хэрэгжилтийг үнэлэн, тасралтгүй сайжруулна.
- 3.1.3 НДХ нь энэхүү бодлогын дагуу компанийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах зорилгоор ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх захирлын залгамжлагчийн бэлэн байдлыг хангахад анхаарч ажиллах бөгөөд Менежмент багийн удирдлагуудын залгамж халааны тасралтгүй байдалд хяналт тавин ажиллана.
- 3.1.4 Гүйцэтгэх захирал нь Залгамж халааны бодлого, зорилтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхээс гадна бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, Менежмент багийн удирдлагуудын залгамж халааны бэлэн байдлыг хангахад ХНГ-ыг чиглүүлэн удирдлагаар хангаж ажиллана.
- 3.1.5 ТУЗ-ийн ажлын алба нь Залгамж халааны бодлого, зорилтыг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангах, ТУЗ-ийн гишүүдийн залгамж халааны бэлэн байдлыг хангахад НДХ-той хамтран ажиллана.
- 3.1.6 ХНГ нь Залгамж халааны бодлого, зорилтыг боловсруулан батлуулах, хэрэгжилтийг хангах, Менежмент багийн удирдлагуудын залгамж халааны бэлэн байдлыг хангахад Гүйцэтгэх захиралтай хамтран ажиллана.
- 3.1.7 Менежмент багийн удирдлагууд нь Залгамж халааны бодлого, зорилтыг хэрэгжүүлж, байнгын сайжруулалтыг дэмжин, үр нөлөөтэй байдлыг ханган, залгамж халааны зарчмуудыг баримтлан ажиллана.

3.2 Хяналт ба үнэлгээ

- 3.2.1 ТУЗ нь Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд тогтмол хяналтыг тавьж, заавар чиглүүлгээр хангана.
- 3.2.2 Гүйцэтгэх захирал нь Менежмент багийн удирдлагуудын гүйцэтгэлтэй сар бүр танилцан, үнэлгээ хийнэ.
- 3.2.3 НДХ нь Менежмент багийн гишүүдийн ажлын гүйцэтгэлтэй хагас жил тутам танилцаж, хяналт тавин дүгнэлт гаргана. Шаардлагатай тохиолдолд ажлаас чөлөөлөх саналыг Гүйцэтгэх захирал болон ТУЗ-д гаргаж болно.

3.2.4 НДХ нь ТУЗ-ийн гишүүдийн ажлын гүйцэтгэлтэй жил бүр танилцан, үнэлэлт дүгнэлт өгсний үндсэн дээр улираан нэр дэвшүүлэх, эсхүл чөлөөлөх саналыг гаргана.

ТӨГСӨВ.